



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалах яам болон түүний харьяа зарим байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 93,050,705.97 (ерэн гурван сая тавин мянга долоон зуун таван төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий ашиглалтын хугацаа дууссан автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, хавсралтад заасны дагуу Архангай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Бригадын генерал Д.Ганхуяг, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дээрх хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001341
11-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 9 дугаар сарын 17-ны өдрийн
201 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл	Хүлээн авах байгууллагын нэр
1	Тоёота Ландкрузер 105 /Арал № JTECJ09J805512898/	2007/2007	14,096,705.97	Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-т
2	Тоёота Ландкрузер 76 /Арал № JTGEV73J8F9015558/	2015/2015	75,454,000.00	Архангай аймгийн Жаргалант сумын ЗДТГ-т
3	Тоёота Приус-20 /Арал № NHW200004659/	2003/2012	3,500,000.00	Архангай аймгийн ЗДТГ-т
Нийт дүн			93,050,705.97	
			(ерэн гурван сая тавин мянга долоон зуун таван төгрөг ерэн долоон мөнгө)	